

чиглэлээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлага тулгараад байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоригдогчдыг барилга болон дотоодын барилгын материалын үйлдвэрлэл, хувь хүн албан байгууллагуудтай гэрээгээр ажиллуулах, хорих ангийн үйлдвэрийн бүсэд мод модон материал, чулуун эдлэл, газар тариалан, мал аж ахуй, үйлчилгээнд ажиллуулж хоригдогчдод хөдөлмөрийн хөлсийг хуулийн дагуу олгож байгаа бөгөөд 2013 онд нийт 5581 хоригдогч ажлын байраар хангагдан 1117,8 сая төгрөгийн цалин бодогдож, шүүхийн төлбөртэй 335 хоригдогчийн цалингаас 156,4 сая төгрөг суутган шилжүүлсэн байна.

Хорих ял эдлэгсдээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгалд хийх, үүний тулд ялтныг ажлын байраар хангах, нөгөөтэйгүүр ар гэр, төрөл төрөгсдөөс хохирлыг барагдуулах, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах зэрэг арга хэлбэрүүдээр явуулж байгаа боловч, хохирогчийн эрх ашгийг хангаж, хохирлыг барагдуулах ажиллагаа төдийлэн үр дүнд хүрэхгүй байгаа нь тодорхой харагдаж байна.



С.БУЯНЗАЯА

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ, БУСАД ХУУЛИУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗӨРҮҮТЭЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бол шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх шинж чанартай төдийгүй нийгмийн өвөрмөц харилцааг зохицуулж буй үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулахад эрх зүйн таатай орчин чухал ач холбогдолтой байх нь гарцаагүй. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь зарим нэг хуулиудын эрх зүйн зохицуулалттай зөрүүтэй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Энэ ч үүднээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учруулж байгаа гол хүчин зүйлсийн нэг бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим бүлэг, зүйл, заалт амьдралд нийцээгүй, бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн, хуулийн хийдэлтэй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй заалтууд байдаг.

Үүнд дараах зарим зүйл заалтуудыг зөрүүтэй зохицуулагдсан гэж тодорхойлон дурдаж болно.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль – Банкны тухай хууль

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 – Төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар

хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, 53 дугаар зүйлийн 53.3 – Гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь харилцах болон хадгаламжийн дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө болон бусад үнэт зүйлээс төлбөрийг гаргуулна,

Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 – Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно, 7.2.3 – Шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авилгатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн.

Зөрүүтэй байдал: Банкны тухай хуулиар тодорхой хэдэн байгууллагад мэдээлэл өгч болохоор хуульчилсан байх боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдээлэл өгөх боломжгүй мэт заагдсан.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 – Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллага заавал биелүүлнэ,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 – Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах үндэслэл, хугацаагаар шүүгчийн захирамжаар түдгэлзүүлнэ, 15.2 – Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах үндэслэл, хугацаагаар

шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор түдгэлзүүлнэ.

Зөрүүтэй байдал: Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх шинж чанартай байдаг боловч үүнийг үгүйсгэж түдгэлзүүлж байгаа нь шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх шалтгаан болдог.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль – Цагдаагийн албаны тухай хууль

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 – Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, олж тогтооход өөрт байгаа мэдээлэл өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад саад учруулж байгаа, эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн бол цагдаагийн байгууллага туслалцаа үзүүлж болно,

Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 – Цагдаагийн байгууллага доор дурдсан захиргааны хяналтын үүргийг гүйцэтгэнэ, 12.1.6 – Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах.

Зөрүүтэй байдал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заагдсан зарим үүргийг Цагдаагийн албаны тухай хуульд тусгаагүй байгаа нь цагдаагийн байгууллага туслалцаа үзүүлэх, эсхүл үзүүлэхгүй байх асуудал нь тодорхой бус байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 – Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг төлбөр төлөгч, төлбөр авагчийн алины нь ч оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэж болно,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 – Өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн

төлбөр төлөгчид холбогдох шийдвэрийг төлбөр авагчийн саналаар төлбөр төлөгчдийн аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 – Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой шийдвэрийг төлбөр авагчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 – Шийдвэр гүйцэтгэх явцад төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын хаяг өөрчлөгдсөн, эд хөрөнгө байхгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь энэ талаар тэмдэглэл үйлдэж ахлах шийдвэр гүйцэтгэгч болон төлбөр авагчид мэдэгдэнэ,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 – Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 13.8-д заасан тэмдэглэлийг гүйцэтгэх баримт бичгийн хамт төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ буюу түүний ажиллаж байгаа, эсхүл түүний эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд явуулж, энэ тухай төлбөр авагч болон гүйцэтгэх баримт бичиг үйлдсэн бусад байгууллагад мэдэгдэнэ.

Зөрүүтэй байдал: Хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн журмаар гүйцэтгэхээр заасан боловч зарим тохиолдолд төлбөр авагчийн оршин суугаа болон эд хөрөнгө нь байгаа нутаг дэвсгэрийн тойргийн журмаар гүйцэтгэхээр заасан нь хоорондоо зөрчилдөөнтэй зохицуулалт болсон. Мөн гүйцэтгэх баримт бичгийг тойргийн харьяаллаар шилжүүлж байгаа тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэр гаргасан шүүх болон бусад байгууллагад мэдэгдэж байгаа

нь ач холбогдолгүй, цаг хугацаа алдах явдлыг бий болгож байна.

Дүгнэж хэлэхэд шинэчлэлийн засгийн газрын бодлого, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй хууль зүйн салбарын эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулахад хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий, харилцан хамааралтай салбар эрх зүйн хуулийн зохицуулалтуудыг нарийн судалж боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

